# РОУМИНГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАРЫН АВЛАГА

mobicom.mn

mobicom

## АГУУЛГА


### 1. ГАДААДАД АЯЛАХЫН ӨМНӨ / 1-3 /

1.1. Гар утасны роуминг нээх тохиргоо

1.2. Сүлжээний горим сонгох тохиргоо

1.3. Аялах гэж буй улсынхаа үнийн мэдээлэлтэй танилцах заавар

1.4. Роуминг үйлчилгээ идэвхжүүлэх дараалал

1.5. Анхааруулга:

- Хэрэглээ хязгаарлах үйлчилгээ
- Задгай дата
- Satellite үйлчилгээ
- Роуминг үйлчилгээ тасалдах

1.6. Зөвлөмж:

- Гар утаснаасаа дата хэрэглээгээ хянах

2. ГАДААДАД АЯЛЖ БАЙХДАА / 3-5 /

2.2. Сим апплет тохиргоо

2.2. Оператор сонгох тохиргоо

2.3. Дата роуминг ажиллахгүй байх үед хийх APN тохиргоо

3. ДУУДЛАГА ХИЙХ ЗААВАР / 6 /

4. МЕССЭЖ ИЛГЭЭХ ЗААВАР / 6 /

5. ЭХ ОРОНДОО БУЦАЖ ИРЭХДЭЭ / 6 / хийх алхмууд

- Роуминг үйлчилгээг хаах

# 1. ГАДААДАД АЯЛАХЫН ӨМНӨ

## 1.1. ГАР УТАСНЫ РОУМИНГ ТОХИРГООГ НЭЭНЭ ҮҮ

**Samsung** — android

Settings → Connections → Mobile Networks → Data Roaming

**iPhone** — iOS

Settings → Cellular/ Mobile Data* → Cellular data options/ Mobile data options* → Data roaming

**Huawei** — HarmonyOS

Settings → Wireless & networks → Mobile networks → Data Roaming

* Гар утасны загвар, үйлдлийн системийн хувилбараас хамаарч цэсийн нэр өөр байх боломжтой.
* Хэрэв та давхар сим ашигладаг бол эхлээд роуминг идэвхжүүлэх симээ сонгосны дараа дээрх тохиргоог хийнэ үү.

## 1.2. СҮЛЖЭЭНИЙ ГОРИМ СОНГОХ ТОХИРГООГ ХИЙНЭ ҮҮ

| Samsung | iPhone | Huawei |
|---|---|---|
| android | iOS | HarmonyOS |
| Settings | Settings | Settings |
| Connections | Cellular/ Mobile Data* | Wireless & networks |
| Mobile Networks | Cellular data options/ Mobile data options* | Mobile networks |
| Network mode | Voice & Data | Preferred network mode |

### СҮЛЖЭЭНИЙ ГОРИМУУД

a. Өндөр хурдны интернэт ашиглах тохиолдолд **4G**, эсвэл **LTE** тохиромжтой. Харин дуудлага хийх үед автоматаар **3G** горим руу шилжинэ.

b. Интернэт болон дуудлага хосолсон горимд **3G** сүлжээ тохиромжтой.

c. **2G** нь зөвхөн дуудлагын сүлжээний горим тул уг горимыг дангаар сонгох нь учир дутагдалтай юм.

Сүлжээг сонгосны дараа сүлжээний түвшин ( .ıl ) харагдах ба сонгосон операторынхоо нэрийг харах боломжтой.

* Хэрэв та давхар сим ашигладаг бол эхлээд симээ сонгосны дараа дээрх сүлжээний тохиргоог хийнэ үү.

## 1.3. АЯЛАХ ГЭЖ БУЙ УЛСЫНХАА ҮНИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ ТАНИЛЦАНА УУ

599 дугаар руу өөрийн зорчих улсын нэрийг англиар илгээнэ үү.
Жишээ нь: 599 дугаарт China гэж илгээх.
Жич: Хятад улсад дата багц авсан бол Хонг Конг, Макао, Сингапурт хамаарахгүй.

## 1.4. РОУМИНГ ҮЙЛЧИЛГЭЭ ИДЭВХЖҮҮЛЭХ ДАРААЛАЛ

| | | Мессэжээр | Апликейшнаар |
|---|---|---|---|
| АЛХАМ 1 | Роуминг нээх | ON гэж бичээд > 599 дугаар руу илгээх * | mobicom апликейшны "Үйлчилгээ" цэснээс роуминг үйлчилгээг нээх |
| АЛХАМ 2 | Дуудлага хүлээн авах роуминг нээх | АЛХАМ 1 > ON VOICE гэж бичээд > 599 дугаар руу илгээх * | - |
| НЭМЭЛТ АЛХАМ | Задгай дата нээх | АЛХАМ 1 > ON Z гэж бичээд > 599 дугаар руу илгээх | Урьдчилсан төлбөрт, Хосолсон төлбөрт хэрэглэгч Задгай дата үйлчилгээг нээх боломжгүй. |
| Ярианы роуминг үйлчилгээг нээх | | Мобикомын салбарт очин барьцаа байршуулж гэрээ хийснээр идэвхэжнэ. Тухайн улсад очиход мессэж, дата роуминг үйлчилгээ автоматаар нээгдэнэ. | |

*Роуминг үйлчилгээг нээх үед мессэж илгээх хүлээн авах болон дата багцуудыг идэвхжүүлэх боломжтой болно

*Дараа төлбөрт хэрэглэгч гаднаас дуудлага хүлээж авахгүй байхыг хүсвэл OFF VOICE гэж бичээд 599 дугаар руу илгээнэ үү.

*Урьдчилсан төлбөрт болон Хосолсон төлбөрт үйлчилгээний хэрэглэгч ярианы роуминг үйлчилгээг нээхдээ барьцаа төлбөр төлөх шаардлагагүй.

## 1.5. АНХААРУУЛГА

### ХЭРЭГЛЭЭ ХЯЗГААРЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХЭРЭГЛЭГЧИД ХЭРЭГЛЭЭГЭЭ ХЯНАХЫГ ХҮСЬЕ

Хэрэглээ хязгаарлах нэмэлт нөхцөл нь Дараа төлбөрт үйлчилгээний хэрэглэгчдийн дугаарын хэрэглээг үе шаттайгаар мэдээлэх, хэрэглээ хязгаарлах түвшинд хүрсэн тохиолдолд гарах хэрэглээг хязгаарлах нэмэлт үйлчилгээ юм.

### SATELLITE ҮЙЛЧИЛГЭЭ

Роуминг үйлчилгээ идэвхжүүлсэн хэрэглэгч агаарт, далай тэнгист сүлжээгээ унтраалгүй зорчсон тохиолдолд Satellite буюу сансрын холбоо үйлчилгээ нь автоматаар идэвхжих бөгөөд үйлчилгээний төлбөр өндөр тооцогддогийг анхаарна уу.

### ЗАДГАЙ ДАТА

Задгай дата үйлчилгээний төлбөр өндөр тооцогддогийг анхаарна уу.

### РОУМИНГ ҮЙЛЧИЛГЭЭ ТАСАЛДАХ

Хэрэв та хуучин **(2019 оноос өмнөх)** симтэй байгаа бол Хятад, Өмнөд Солонгос, Япон, Хонг Конг, ОХУ, Бельги, Казахстан гэсэн 7 улсаас өөр улс руу зорчиж буй тохиолдолд роуминг үйлчилгээ тасалдаж болзошгүйг анхааруулж байна.

## 1.6. ЗӨВЛӨМЖ

Та дараах үйлдлийг гар утсан дээрээ хийж, дата хэрэглээгээ давхар хянах боломжтой.

| Samsung | iPhone | Huawei |
|---|---|---|
| android | iOS | HarmonyOS |
| Settings | Settings | Settings |
| Connections | Cellular/ Mobile Data | Wireless & networks |
| Data Usage | Current Period | Data Usage |

* Samsung болон Huawei дээр дата хязгаараа тогтоож, хязгаарлалтдаа хүрсэн тохиолдолд сануулга иргүүлэх боломжтой.

* iPhone дээр "Reset Statistics" гэсэн тохиргоог хийснээр одоогийн хэрэглээний мэдээлэл устаж, зөвхөн роуминг хийх үеийн дата хэрэглээний мэдээлэл харагдах юм.

# 2. ГАДААДАД АЯЛЖ БАЙХДАА

## 2.1. СИМ АППЛЕТ ТОХИРГОО

### Samsung

**android**

- Home
- mobicom /sim app/
- Global Roaming
- Activate Automatic Mode*

### iPhone

**iOS**

- Settings
- Cellular/ Mobile Data
- SIM Applications
- Global roaming
- Activate Automatic Mode*

### Huawei

**HarmonyOS**

- Home
- Tools
- mobicom /sim app/
- Global roaming
- Activate Automatic Mode*

* Хэрэв Солонгос, Хятад, Бельги, Орос, Япон, Хонг Конг, Казакстан гэсэн 7 улсад зорчиж байгаа бол Сим апплет нь "Home" тохиргоогоор ажиллана.
* Харин дээрх 7 улсаас бусад улсад зорчиж байгаа бол "Host" тохиргоогоор ажиллана.

## 2.2. ОПЕРАТОР СОНГОХ ТОХИРГОО

Ухаалаг гар утас нь интернэт болон тухайн улсын сүлжээтэй автоматаар холбогддог ч зарим тохиолдолд гар утасны маркаас хамааран автомат тохиргоо алдагддаг. Эдгээр тохиолдолд дараах тохиргоог хийнэ үү.




* Автомат тохиргоог унтраасны дараа сүлжээг хайлган 1 минут орчим хугацаанд хүлээх бөгөөд боломжтой сүлжээнүүд гарч ирсний дараа операторын нэрийг сонгоно. Сүлжээг сонгосны дараа сүлжээний түвшинг ( ) харуулна. Сонгосон операторынхоо нэрийг харах боломжтой.

## 2.3. APN ТОХИРГОО ХИЙХ:

/Дата роуминг ажиллахгүй байгаа үед дараах тохиргоог хийнэ үү/

### iPhone

### iOS

Утасныхаа интернэт хөтчөөр http://unlockit.co.nz/ гэсэн холбоосыг бичин орох ба зааврын дагуу "Unlockit.co.nz" нэртэй апликейшн суулгана. Суулгах явцад "Create new APN" сонголтыг хийхэд тухайн улсын сүлжээ автоматаар гарч ирэх ёстой.

* Үүний дараа суулгасан апликейшн дээр тухайн улсын APN автоматаар тохируулагдана.

1. unlockit.co.nz холбоос руу орох
2. Create new APN
3. Create APN
4. Allow
5. Close
6. Гар утасны Settings
7. Profile downloaded
7. Install
8. Done

**Samsung**

android

- Settings
- Connections
- Mobile Network
- Access Point Names
- +(to add)
- Name: Internet
- APN: Internet
- Save

**Huawei**

HarmonyOS

- Settings
- Wireless & networks
- Mobile networks
- Access Point Names
- New APN
- Name: Internet
- APN: Internet
- Save

# 3. ДУУДЛАГА ХИЙХ ЗААВАР

Мобикомын хэрэглэгч гадаадаас Монголын үүрэн телефон хэрэглэгч рүү дуудлага хийх:

> + + 976 + Гар утасны дугаар

Мобикомын хэрэглэгч гадаадаас Монголын суурин утас руу дуудлага хийх:

> + + 976 + Суурин утасны дугаар

Мобикомын хэрэглэгч гадаадаас тухайн аялж буй орныхоо үүрэн телефон хэрэглэгч рүү дуудлага хийх:

> Гар утасны дугаар

Мобикомын хэрэглэгч гадаадаас тухайн аялж буй орныхоо суурин утас руу дуудлага хийх:

> Улсын код + Суурин утасны дугаар

Мобикомын хэрэглэгч гадаадаас өөр улсын үүрэн телефон хэрэглэгч рүү дуудлага хийх:

> + + Тухайн улсын код + Гар утасны дугаар

Мобикомын хэрэглэгч гадаадаас өөр улсын суурин утас руу дуудлага хийх:

> + + Тухайн улсын код + Хотын код + Суурин утасны дугаар

# 4. МЕССЭЖ ИЛГЭЭХ ЗААВАР

Монголын үүрэн телефон буюу Мобиком, Скайтел, ЖиМобайл Юнителийн хэрэглэгч рүү мессэж илгээхдээ гар утасны дугаарыг шууд бичнэ.
Гадаадын өөр операторын хэрэглэгч рүү мессэж илгээхдээ:

+ + Тухайн улсын код + Гар утасны дугаар

Мессэжээр тухайн улсын үнэ тарифын мэдээллийг авахдаа 599 дугаар руу зорчих улсын эхний 4 үсгийг, эсвэл бүтнээр нь англиар бичиж илгээнэ.

RUSSIA

# 5. ЭХ ОРОНДОО БУЦАЖ ИРЭХДЭЭ

| | | Мессэжээр | Апликейшнаар |
|---|---|---|---|
| АЛХАМ 1 | Мессэж роуминг үйлчилгээг хаах | OFF гэж бичээд 599 дугаар руу илгээх | mobicom апликейшны "Үйлчилгээ" цэснээс мессэж роуминг үйлчилгээг хаах |
| НЭМЭЛТ АЛХАМ | Задгай дата хаах | OFF Z гэж бичээд 599 дугаар руу илгээх | Урьдчилсан төлбөрт, Хосолсон төлбөрт хэрэглэгч Задгай дата үйлчилгээг ашиглах боломжгүй. |
| Ярианы роуминг үйлчилгээг хаах | | Эх орондоо буцаж ирснээр автоматаар Мобикомын сүлжээнд холбогдоно. Хаах хүсэлт явуулах шаардлагагүй. Цуцлуулахыг хүсвэл салбарт очно уу. | |

2222, +976 1800-2222 | Төлбөргүй лавлах

+976 1900-2222 | Төлбөртэй лавлах

customercare@mobicom.mn

mobicom.official

mobicom апликейшн